



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/27

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сум үүсэн байгуулагдсаны түүхт зуун жилийн ойг угтаж “Цэгцтэй хашаа Цэвэр гудамж” аяныг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2.Аян зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Баянмөнх (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ю.Цэнгэлмөрөн (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Р.Амарбаясгалан (Цэцэрлэгийн эрхлэгч)

Ж.Лхамсүрэн (Соёлын төвийн дарга)

С.Гүрсүрэн (Эрүүл мэндийн нийгмийн ажилтан)

Б.Бат-Амгалан (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Хүрэлбаатар (Байгаль хамгаалагч)

Г.Ганхөлөг (Газрын даамал)

С.Даваадорж (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Жамбалдорж (Тархвар зүйч)

Г.Баасанцэрэн (Хэсгийн төлөөлөгч)

Т.Болдбаатар(1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Билэгдэмбэрэл (2 дугаар багийн Засаг дарга)

Х.Даш-Очир (3 дугаар багийн Засаг дарга)

Б.Одхүү (4 дүгээр багийн Засаг дарга)

Ц.Наранбямба (Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Энхцэцэг (Худалдаа эрхлэгчдийн ахлагч)

3.Аяны удирдамжийг хавсралтаар баталсугай


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бат-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАТ-ЭРДЭНЭ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын
Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн А/27 дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ



2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Эрдэнэт

"Сумын 100 жилийн ойг угтаж Цэгцтэй хашаа Цэвэр гудамж" аян

Зорилго: Шинэ-Идэр сум байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын аяныг өрнүүлж сумын төвийн гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулах нийтийн эзэмшлийн талбай айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах амьдрах орчноо сайжруулахад ард иргэдтэйгээ хамтран ажиллаж дэмжин урамшуулж олон нийтэд суртчилан таниулахад оршино.

Хамрах хүрээ: Иргэд, аж ахуйн нэгжүүд.

Хугацаа: 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдөр хүртэл.

Хэрэгжүүлэгч байгууллага: Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газар

Хийгдэх ажил:

- 1.Нийтийн эзэмшлийн талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, ил задгай хог хаягдал, угаадас асгадаггүй байх
- 2.Гэр хороолол, орон сууцны гадна тохижилтыг сайжруулах
- 3.Хайс хашааг стандартад нийцүүлэх, нэгэн жигд өнгөтэй болгох (шохойдож будсан) гудамж хашааны догол тэгшлэх
- 4.Хашааны гадна талд жорлон муу усны нүхний шороогүй байх

Шагнал урамшуулал:

Зохион байгуулалтыг сайтар гүйцэтгэж хэвшил болгосон 10 айл өрхийг шалгаруулж урамшуулал олгоно.

Шагналын сан: 1,000,000 (нэг сая) төгрөг

__оОо__